



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 26/07

Улаанбаатар хот

**Багахангай дүүргийн 2025 оны
төсвийн гүйцэтгэлийг батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VII дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2025 оны төсвийн орлогын гүйцэтгэлийг нийт 14,544,859,9 мянган төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг нийт 14,226,670.5 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

2. Дүүргийн төсвийн орлогын гүйцэтгэлийг нэр төрөл бүрээр нэгдүгээр хавсралтаар, төсвийн зарлагын гүйцэтгэлийг байгууллагын зардлын зүйл бүрээр хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Зөвлөл, Төсөв, санхүү, эдийн засгийн хороо (Б.Болормаа)-нд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

1226010024